

## ӨГҮҮЛЭЛ

**Орчин үеийн дипломат ажиллагаанд үзүүлсэн  
Францын нөлөө**

Монгол-Францын хооронд дипломат харилцаа  
тогтоосны 55 жилийн ойд зориулав.

***Пүрэвдоржийн Мягмардорж***

*ХИС-ийн Олон улс, нийгэм судлалын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D.)  
myagmardorj@humanities.mn*

**Хураангуй:** Орчин үеийн дипломат ажиллагааны дэг сургууль, нэр томъёо, бүтэц зохион байгуулалт, ахлах дараалал зэргийг тодорхойлж ирсэн улс бол яах аргагүй Франц юм. Францын дипломат ажиллагаа, дипломат алба нь асар их түүхэн уламжлалтайн зэрэгцээ бусад улс төдийгүй дэлхийн дипломатын хөгжилд томоохон нөлөө үзүүлсэн байдаг. Дипломат алба нь үүсгэн байгуулагдсан цаг үеэс хойш Францын үе үеийн төр засаг дипломат албаныхаа бүтэц зохион байгуулалтад ихээхэн ач холбогдол өгч, түүнийг хөгжүүлэх, үйл ажиллагааг нь илүү боловсронгуй болгох тал дээр анхаарч, дипломатчдыг бэлтгэн сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх ажлыг эрчимтэйгээр явуулж иржээ. Дипломат ажиллагааны судлаач, түүхч мэргэдийн дэвшүүлсэн онол, үзэл баримтлал, тэмдэглэл зэргээс үзэхэд орчин цагийн дипломат ажиллагааны хэв маяг, түүнийг эрхлэн явуулах арга ухаан, шинжлэх ухааны үндэс суурь нь Францаас гаралтай төдийгүй 18-р зууны үеэс эхлэн франц хэл латин хэлийг шахан олон улсын харилцаа, дипломат ажиллагааны салбарт голлох хэл болсоор өнөөдрийг хүрсэн билээ.

Энэхүү судалгааны өгүүллээрээ Францын дипломатын дэг сургуулийн орчин цагийн дипломат ажиллагаанд оруулсан хувь нэмэр болон үзүүлсэн түүхэн нөлөөг судлаж үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьлоо.

**Түлхүүр үгс:** Орчин үеийн дипломат ажиллагаа, дипломат алба, Францын дипломат ажиллагаа.



## Оршил

Орчин үеийн олон улсын харилцааны үндсэн оролцогч болох үндэсний төрт улсын гадаад бодлогоо хэрэгжүүлэх, олон улсын харилцаа болон дэлхийн бодлогын тавцанд ашиг сонирхолоо хамгаалах үндсэн хэрэглүүр нь дипломат ажиллагаа юм. Аливаа улс гүрэн өөрийн засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн гадаад таатай орчинг бий болгож улмаар дотоод улс төр, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлыг дээшлүүлэн хангахын тулд дипломат албаараа дамжуулан хоёр болон олон талт чуулга уулзалт, яриа хэлэлцээ, гэрээ хэлэлцээр байгуулах зэрэг төрөл бүрийн арга хэрэгсэлийг ашиглан хэрэгжүүлдэг.

Олон улсын харилцаа үүсч бий болсон цаг үеэс эхлэн улс хоорондын харилцааны аливаа асуудлыг энхийн замаар буюу дипломат арга замаар шийдвэрлэх оролдлого хийсээр ирсэн байдаг. Тухайлбал, эртний Египет, Месопотамын улсууд цэрэг-аюулгүй байдлын гэрээ байгуулах зорилгоор элч төлөөлөгч илгээх, бэлэг сэлт солилцох ажиллагааг түгээмэл ашигладаг байсан бол эртний Энэтхэгийн төрт улсын гадаад бодлогод “хүч үл хэрэглэх” бодлого зонхилж байв.<sup>1</sup> Эртний Хятадын хувьд өөрсдийн суурин соёл иргэншлийг хамгаалахын тулд холбоотон олох зорилгоор өөрийн элч төлөөлөгчдийг Энэтхэг, Месопотам, Персийн эзэнт гүрэн, Грек хүртэл

зарж байсан ба эндээс улбаалан Ромын Эзэнт Гүрэн хүрсэн “торгоны зам”-ыг байгуулах шийдвэр гаргаж байв. Тэгвэл Монголын Эзэнт Гүрний үед монголчууд дипломат элчийн ахлах дарааллыг бий болгосон ба нэн ялангуяа дипломат элчийн халдашгүй дархан байдлыг баталгаажуулж өгснөөрөө орчин үеийн дипломат ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан байдаг. Харин Грек, Ром болон Византын дипломат ажиллагаа нь дараа үеийн дипломат ажиллагааны хөгжилд томоохон нөлөө үзүүлсэн. Тухайлбал, дипломат баримт бичиг, дипломат ёс горим, ёслол, дипломатын ардчилсан зарчим, олон улсын эрх зүй, дипломат ажиллагааны чиг үүрэг зэрэг олон зүйлсийг энд дурьдаж болно. Грек, Ромын дипломат ажиллагаа нь их гүрний хувьд хэрхэн гадаад бодлого, дипломат ажиллагааг эрхлэн явуулах талаар бусад улс гүрэнд томоохон үлгэр болсон.

Дундад зууны үеэс Европын улсууд харилцан бие биедээ байнгын элч төлөөлөгч (**alter ego**<sup>2</sup>) солилцох болсноор дипломат ажиллагаа нь улсуудын гадаад харилцаанд томоохон байр суурь эзлэх болж улмаар дипломат ажиллагаа, дипломат алба нь орчин цагийн анхны хэлбэрээ олж эхэлсэн байна. Ялангуяа Италийн “сэргэн мандалт”-ын эрин үетэй давхцан 14-15-р зууны үеэс Италийн худалдааны хүчирхэг хот-улсуудын хаад Европын

1 МЭӨ 4-3-р зууны үед Энэтхэгийн Чандрагүпта Маурья хааны зөвлөх, бирман Вишнигуптагийн (Каутилья) боловсруулсан Төрийн бодлогын тухай цогц бүтээл болох “Арташтра” нь гадаад бодлогодоо дайнаас татгалзах тухай санааг гочлон тусгажээ.

2 Латин хэлний “2-догч би” хэмээх утга.

болон Дорнын улсуудад байнга суух төлөөлөгчдийг томилон ажиллуулах болсноор Италичууд дипломатын хөгжилд эргэлт хийсэн хэмээн үзэж болно. Гэхдээ Италийн философич, дипломатч Никколо де Бернардо Маккиавеллигийн нэртэй холбоотой “хууран мэхлэх ажиллагаа” энэ үеийн дипломат ажиллагаанд газар авсан нь түүхийн бодит баримтаас харагддаг. Италийн дараачаар дипломат арга ажиллагаа, дипломат алба, элчин сайдын институтыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн улс бол Франц юм.

Орчин үеийн дипломат ажиллагааны нэр томъёо, ахлах дараалал, дипломат албаны төвийн болон хилийн чанад дахь байгууллагын бүтэц зохион байгуулалт, мөн дипломат ёслолын дэг жаягийг тодорхойлж байгаа улс бол яах аргагүй Франц юм. Үүнтэй холбоотойгоор Францын дипломатын талаар олон арван түүхч, судлаач, улс төрчид өөр өөрсдийн тодорхойлолтыг хийсэн байдаг. Тухайлбал: Германы эрдэмтэн, дипломатын түүх судлаач Р.Заллет “Францын Гадаад Хэргийн Яам болон дипломат алба нь зуун зууны гайхамшигт түүхтэй ба өөр нэг ч улс дипломатын салбарт энэ улстай өрсөлдөхүйц түүхэн уламжлал үгүй юм”<sup>3</sup> гэсэн бол Францын ерөнхийлөгч асан Жак Ширак “21-р зуунд Францын олон улсын тавцан дахь байр суурь, алдар нэр нь орчин цагийн хөгжингүй улс хэмээх нэр хүндээс гадна гадаад

**бодлого, дипломат ажиллагааны уламжлал, залгамж шинж чанарт тулгуурлах болно”** хэмээн хэлсэн байдаг.<sup>4</sup>

Дипломатын уламжлалын хувьд Францтай өрсөлддөг гол улс болох Британийн дипломатын хүрээнд хүртэл Францын дипломат ажиллагааг өндрөөр үнэлсэн байдаг. Тухайлбал: Английн дипломатч, дипломат ажиллагааны нэрт судлаач Х.Никольсон “17-18-р зууны үеийн Францын дипломат ажиллагаа нь Европын бусад улсад үлгэр жишээ болсон”<sup>5</sup> хэмээсэн бол Их Британийн Гадаад Хэргийн сайд Уильям Хааг<sup>6</sup> 2012 онд Британийн Гадаад Яамыг 2015 он гэхэд дэлхийн хамгийн шилдэг дипломат алба болгох зорилтыг тодорхойлсон бөгөөд энэхүү зорилтоо биелүүлэх зорилгоор улс төр, бизнес, сэтгүүл зүй болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэхүү хэлэлцүүлэгийн үед ГХХНЯ-ны Байнгын Нарийн Бичгийн дарга Саймон Фрэйзер “Британийн дипломатчид дэлхийн шилдэг хэмээн нэрлэгдэхийн тулд Францын дипломатчдаас суралцах хэрэгтэй. Учир нь Францын дипломат алба бол хамгийн шилдэг дипломат алба юм”<sup>7</sup> хэмээн үнэлсэн байдаг.

Дээрх түүхэн хураангуй, зарим нэг судлаач болон улс төрчдийн тодорхойлолт болон үнэлгээнээс харахад Франц нь орчин цагийн

3 Зонова.Т.В. Дипломатия Иностранных Государств. Москва., 2004. стр.38

4 Зонова.Т.В. Дипломатия Иностранных Государств. Москва., 2004. стр.39

5 Никольсон.Г. Дипломатическое искусство. М., 1962. стр. 74

6 2010-2014 оны хооронд ИБУИНХУ-ын ГХ-ийн сайдаар ажиллаж байсан.

7 Kayte Rath, French diplomatic service is the world's best, UK says, BBC News, 8 November 2012 <https://www.bbc.com/news/uk-politics-20218377>

дипломат ажиллагааны онол, практикийн үндэс, тэр дундаа дипломатын дэг сургуулийг бий болгосон ажээ. Иймээс Францын дипломат ажиллагаа, дипломат албаны уламжлалын талаар түүхэн

судалгаа хийж орчин цагийн дипломат ажиллагаанд яг ямар хувь нэмэр оруулсан талаар, түүхэн нөлөө нь юу байсан талаар судлаж тодруулах нь энэхүү ажлын үндсэн зорилго юм.

### Үндсэн хэсэг

Францын дипломат албаны үүсэл хөгжил нь төвлөрсөн төр засаг бүхий үндэсний төрт улс байгуулагдсан үеэс буюу Францын улс олон улсын харилцаанд оролцож эхэлсэн цаг үеэс эхлэлтэй. МЭ-ний 10-р зууны сүүлчээр Уго Капет<sup>8</sup> Францын хаан ширээнд сууж, улмаар Капетын удмын хаадын төр барьсан түүхэн үе эхэлсэн ба энэ цагаас хойш даруй 400 гаруй жилийн турш Францын төрийн бодлого нь Францын газар нутгийг нэг удирдлага дор нэгтгэхэд чиглэгдэж байв.

Харин 11-р Людовик хаан (1461-1483) Францын төрийн эрхэнд гарч ирснээр дипломат ажиллагааг төрийн бодлогын нэг гол хэрэглүүр болгох тал дээр илүүтэйгээр анхаарч эхэлсэн юм. Түүний удирдлага дор феодал ноёдыг хааны зарлиг, тушаалгүйгээр олон улсын хэрэгт оролцуулахгүй байх мөн бусад улс оронтой харилцах харилцааг хаан онцгой эрхтэйгээр удирдан явуулдаг болжээ. 11-р Людовикийн хаанчлалын үед гадаадад бүрэн эрхт элч, байнга суун ажиллах

төлөөлөгчдийг илгээж эхэлсэн ба гадаад улсуудад томилогдон ажиллах элчин төлөөлөгчийн үйл ажиллагааг байнгын болгож өөрчлөх эхлэлийг тавьжээ.<sup>9</sup> Тэрээр гадаад хэрэг болон дипломат ажиллагааг хаан өөрийн биеэр удирдан хянадаг тогтолцоог бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Харин Францын хаан 1-р Францис анх удаа 1526 онд Англид (*Charles de Solier, comte de Morette*), 1533 онд Оттоманы хаант улсад суух элчин сайдаа (*Jean de La Forkt*) томилсон бол Францын хаан 3-р Хенрихийн 1589 оны 1-р сарын 1-нд гаргасан тушаалын дагуу гадаад харилцааг удирдан хэрэгжүүлэх онцгой эрхийг Францын төрийн нарийн бичгийн дарга Луи де Револьд шилжүүлсэн байдаг.<sup>10</sup> Үүний гол зорилго нь гадаад хэргийн асуудал эрхэлсэн тусгай хороог байгуулах явдал байлаа. Иймд Луи де Револь<sup>11</sup> нь Францын хамгийн анхны гадаад хэргийн сайдын албыг давхар хашсан төрийн нарийн бичгийн дарга болсон

8 Уго Капет нь 987-996 оны хооронд Францын хаан ширээнд сууж байсан бөгөөд Капетын удмын хаанчлалын эхийг тавьсан юм.

9 Wael Jabbar Jouda, Anass Hamza Mahdib. "The Role of Louis XI in France's Foreign Policy (1461-1483)", International Journal of Innovation, Creativity and Change. Volume 12, Issue 12, 2020 [https://www.ijicc.net/images/vol12/iss12/121218\\_Joud\\_2020\\_E\\_R.pdf](https://www.ijicc.net/images/vol12/iss12/121218_Joud_2020_E_R.pdf)

10 <https://www.diplomatie.gouv.fr/ru/o-ministerstve/istoriya-ministerstva-i-ego-znakovyh-zdaniy/article/decouvrir-l-histoire-et-les-lieux-emblematisques-du-ministere>

11 Луи де Револь 1589 оны 1 сарын 1-нээс 1594 оны 9 сарын 1-ны хооронд Францын гадаад хэргийн сайдын албыг хашсан.

юм.<sup>12</sup> Иймээс ч Франц улсыг гадаад хэргийн сайдын албан тушаалыг бий болгохоосоо өмнө мэргэжлийн дипломатчидтай байсан төдийгүй Гадаад Хэргийн Яамаа байгуулахаас өмнө сайдын албан тушаалыг бий болгосон гэж үздэг.

Тэрээр анхны итгэмжлэгдсэн гадаад хэргийн сайдын хувьд хаанд хамгийн ойр байхаас гадна гадаад харилцааны бүхий л асуудалд анхаарал хандуулах эрхтэй байв. Луи де Револийн тэргүүлсэн гадаад харилцааны асуудал эрхэлсэн тус хороо нь 6 туслахтайгаар үйл ажиллагаагаа явуулж байсан юм.

Хожим 13-р Людовик хааны үед Францын төрийн нэрт зүтгэлтэн, хамба лам Кардинал Ришелье (1624-1642) Францын төрийн сайдын албыг хашиж байхдаа 1626 онд Францын Гадаад Хэргийн Яамыг байгуулсан бөгөөд энэ нь дэлхийн дипломатын түүхэнд анхны гадаад хэргийн яам хэмээн бичигдэн үлджээ. Энэ талаар дипломат ажиллагааны судлаач, Английн нэрт дипломатч Х.Никольсон “17-18-р зууны үед дэлхийд тэргүүлэгч дипломатын сургууль нь маргаангүй Францынх байсан” хэмээн дүгнэжээ.<sup>13</sup>

Кардинал Ришелье “raison d’etat”<sup>14</sup> буюу “үндэсний ашиг сонирхол” гэсэн ойлголтыг олон улсын харилцаанд анх удаа томъёолсон бөгөөд үндэсний эрх ашгаа дээдлэн, гадаад улс орнуудтай харилцах бодлогыг нэгтгэн зангидах байгууллага хэрэгтэй гэж үзсэнээр гадаад хэргийн яамыг анх бий

болгожээ. Нөгөө талаар энэ нь түүний “Эзэн хааныхаа алдрыг гадаад улс гүрний дунд байх ёстой түвшинд нь хуртэл өргөж өгнө” хэмээсэн амлалтаа биелүүлэх алхмынх нь нэг байсан юм. Төрийн сайдын хувьд Ришельегийн улс төрийн бодлогын өмнө үндсэн хоёр зорилго байсан нь Европ дахь Хабсбургийн удмынхны нөлөөг бууруулах, нөгөөх нь улс төрийн эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлэхэд оршиж байлаа.<sup>15</sup> Кардинал Ришелье дипломат ажиллагаа нь байнгын шинж чанартай байх төдийгүй түүнийг хэрэгжүүлэх дипломат албаны үйл ажиллагаа ч байнгын шинжтэй байх хэрэгтэй хэмээх дүгнэлтэд анхлан хүрсэн билээ. Мөн үүний зэрэгцээ улсын гадаад бодлогын гол зарчим нь “үндэсний ашиг сонирхол”-оо ямагт дээдлэхэд тулгуурлах ёстой хэмээн үзсэн билээ.

Кардинал Ришелье гадаад бодлогыг хэрэгжүүлэх, гадаад бодлогын үйл явцад хяналт тавих, дипломат ажиллагааны гүйцэтгэлийг нэг яаманд төвлөрүүлэх нь төрт улсын хувьд амин чухал гэдэгт итгэлтэй байсан юм. Учир нь энэ үед гадаад бодлогод оролцох, дипломат ажиллагааг хэрэгжүүлэх үйл явцад олон янзын төрийн байгууллага оролцох хандлагатай байсан бөгөөд тэрээр ийм байдлыг огт таашаагаагүй билээ. Иймдээ ч 1626 онд Гадаад Хэргийн Яамыг гардан байгуулж гадаад бодлогын үйл явцыг өөрийн хараа хяналтаас огт алдаагүй хэмээн

12 Зонова.Т.В. Дипломатия Иностранных Государств. Москва., 2004. стр.40

13 Мөн тэнд. стр.40

14 “Улсын хэрэг явдал” гэсэн утгатай Франц үг.

15 Zagorin, Perez. *Rebels and Rulers, 1500–1660. Volume II: Provincial rebellion: Revolutionary civil wars, 1560–1660.* Cambridge: Cambridge University Press. (1992)

Х.Никольсон бичиж үлдээжээ.<sup>16</sup>

Ришельегийн үеэс Францын дипломат алба нь өөрийн гэсэн бүтэц зохион байгуулалттай болсон бөгөөд Төвийн байгууллага (Гадаад Хэргийн Яам) болон Хилийн Чанад дахь байгууллага (Дипломат Төлөөлөгчийн Газрууд) хэмээх үндсэн 2 хэсгээс бүрдэх болжээ. Энэ үед Төвийн байгууллага нь томгүй бүтэц бүрэлдэхүүнтэй байсан ба түүхэн баримтад өгүүлсэнээр 1661 онд 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байжээ. Харин хилийн чанад дахь байгууллага нь төвийн байгууллагаа бодвол илүү олон албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байжээ. Х.Никольсон өөрийн бүтээлдээ *“1685 онд Франц улс нь Ром, Венец, Константинополь, Вена, Гааг, Лондон, Мадрид, Лиссабон, Мьюнхен, Копенгаген болон Бернд байнгын Элчин Сайдын Яамаа ажиллууж байсан бол, Тусгай Төлөөлөгчийн Газруудаа Вюртемберг, Пфальц, Майнцад явуулж байсан төдийгүй мөн байнгын Элчин Яамаа Манте, Генуя, Хамбург, Женев болон Флоренц хотуудад тус тус байгуулан ажиллаж байсан. Францын гадаад суух элчин төлөөлөгчид нь Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд, Элчин сайд, Элчин, Байнгын Төлөөлөгч гэсэн 4 зэрэгт хуваагддаг байв”*<sup>17</sup> хэмээжээ.

Кардинал Ришелье, дипломат ажиллагаа бол байнгын шинжтэй, тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд яриа хэлэлцээнд урьдаас сайтар зэхэж бэлдэж байх ёстой гэж үзсэн анхны төрийн зүтгэлтнүүдийн нэг байлаа. Бүр 17-р зууны эхээр тэрбээр дипломат

ажиллагааг амжилттай явуулахад олон нийтийн санаа бодлыг харгалзан үзэх нь маш чухал болохыг онцолж, энэ тал дээр анхаарч ажиллахыг дипломатчдаас шаардаж байлаа.

Гэсэн хэдий ч Кардинал Ришельегийн үндэслэсэн дипломат ажиллагааны үзэл баримтлал нь Францад цаашид ямагт мөрдөгдөөгүй болох нь түүхээс харагддаг. 14-р Людовик хаанаас өмнөх үед Францын феодал ноёдын эрх мэдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор улс төрийн бодлогын шийдвэр гаргалтад хааны нөлөө багасч засаглалын эрх мэдлээ бараг алдаад байлаа. Харин 14-р Людовик гарч ирснээр феодал ноёдын эрх мэдлийг хязгаарлаж, төрийн удирдлагыг нэг гарт төвлөрүүлж чадсан юм. 14-р Людовик хааны үед Франц нь Европт давамгайлах байр суурьтай болсон хэдий ч далай тэнгис дэх Английн ноёрхлын улмаас төдийлөн хүчирхэгжиж чадаагүй юм. 14-р Людовик хаан дайн тулааны зардлыг феодал ноёдоос гаргуулалгүй ядуу давхрагаас байнга гаргуулж байх жишгийг тогтоосон юм.

Түүнийг хаан ширээнээс буусны дараагаар залгамжлагчид нь ч мөн адил доод давхрагынхан болох жирийн ардаас хамаг алба татвараа авдаг байснаар Францын хөрөнгөтний хувьсгал гарах үндсэн нөхцөл бүрэлджээ. 14 болон 15-р Людовик хаадын үед Францын хаад гадаад бодлогын тал дээр маш их эрх мэдлийг өөртөө төвлөрүүлсэн ба өөрсдийн гадаад хэргийн яамны сайд нартай зөвлөлгүүгээр, тэдэнд

16 Никольсон.Г. Дипломатическое искусство. М., 1962. стр. 74

17 Мөн тэнд, стр. 74

асуудлыг мэдэгдэлгүйгээр нууц гэрээ хэлэлцээг гадаадын хаадтай хийдэг болжээ. Ерөнхийдөө дипломат ажиллагаа нь хааны нууц үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэгч арга ажиллагаа болж хувирсан байлаа. Тэд өөрсдийн энэхүү нууцлагдмал дипломат ажиллагааг “Хар кабинет” буюу “хааны нууц” хэмээх нэрлэгдэж байсан хааны дэргэдэх нууц албаар дамжуулан хэрэгжүүлж байв.<sup>18</sup> 18-р зууны дунд үе гэхэд энэхүү нууц дипломат ажиллагаа нь улам хүчээ авч, албан ёсны Гадаад Хэргийн Яамны зэрэгцээ гадаад бодлого, дипломат ажиллагааг хэрэгжүүлдэг төрөлжсөн алба болон хөгжсөн байна. Францын хаадын дэргэдэх энэхүү “хар кабинет” нь Европын бусад улсуудын нууц албадаас маш их илүү эрх мэдэл бүхий байсан бөгөөд өөрийн үйл ажиллагааг өргөн хүрээнд эрхлэн явуулдаг төрийн нууц алба болон хувирсан байна.

14-р Людовикийн хаанчлалын үед буюу 1673 оны 3 сард “Худалдааны хууль” (Pour le Commerce) батлагдсан бөгөөд энэхүү хуулиар консулын эрх, үүргийг тодорхойлж өгчээ.<sup>19</sup> Энэ цагаас эхлэн дипломат гэрээ хэлэлцээр, улс төрийн баримт бичгүүдийг тусгайлан архивлан хадгалах болсон бөгөөд 1712 онд Францын Элчин Сайд нарыг бэлтгэдэг “Улс төрийн Академи” байгуулагдсан байна.<sup>20</sup>

Францын хувьсгалын өмнө гадаад харилцааг Францын гадаад хэргийн яамны нарийн бичгийн дарга бөгөөд

ерөнхий сайд Ш.Вержен тэргүүлж байсан бөгөөд тухайн үед 70 гаруй албан хаагчидтай байжээ. Энэ үед улс төрийн хойд болон өмнөд гэсэн 2 улс төрийн чиглэлийг баримталж байсан бөгөөд хойд чиглэл нь Баруун болон Төв Европын харилцаа, Америктай харилцах харилцааг, харин өмнөд чиглэл нь Зүүн болоод Өмнөд Европ мөн Скандинавын улс орнуудтай харилцах харилцааг тус тус хариуцдаг байжээ.

Кардинал Ришельегийн эрин үеэс Францын хувьсгал хүртэлх үед Франц улс нь дипломат албаны Европ дахь загвар улс болсон юм. 14-р Людовик хааны элчин сайдаар ажиллаж байсан Франсуа Кальер (1645-1717) “Улс орнуудтай хэлэлцээр явуулах арга” хэмээх бүтээл бичихэд нь энэхүү түүхэн үеийн Францын дипломат ажиллагаа, дипломат албаны асар их туршлага гол нөлөө үзүүлжээ. Тэрээр хууран мэхлэлтээс үүдэлтэй, заль мэх дээр үндэслэн явагддаг дундад зууны үеийн дипломат ажиллагааны зонхилох байр суурийг шүүмжилж байсан юм. Оросын нэрт дипломатч “Орчин үеийн дипломат ажиллагаа: онол, практикийн асуудал” бүтээлийг туурвисан В.И.Поповын үнэлсэнээр гагцхүү Ф.Кальерийн энэхүү бүтээл гарснаар дипломат ажиллагаа нь орчин үеийн ойлголтоор хэрэглэгдэж эхэлсэн ба “дипломат ажиллагаа нь шинжлэх ухааны үндэс дээр тулгуурлан явагддаг ёс суртахууны өндөр зарчим бүхий

18 Петров.В.П., Владимаров.Ю.В. Кэ д’Орсэ. Москва.,1966. стр. 24

19 Amalia D. Kessler. A “Question of Name”: Merchant-Court Jurisdiction and the Origins of the Noblesse Commerçante. <https://stacks.stanford.edu/file/druid:jb240xh0328/kessler.pdf>

20 François de Callières. The Art of Diplomacy. University Press of America, 1994. p.189.

ажиллагаа” хэмээн ойлгогдох болжээ.

21

Эртний Грек, Ром, Византаас эхлээд Италийн дипломат ажиллагаагаар батжиж улмаар Европ даяар газар аваад байсан “хууран мэхлэх дипломат ажиллагаа”-г зөвхөн Францын дипломат ажиллагаа л үгүйсгэж чадсан төдийгүй Францын нэрт дипломатч Франсуа Кальер дипломат ажиллагаан дахь хууран мэхлэх явдлыг эрс шүүмжлэн, ёс суртахууны хэм хэмжээг дипломат ажиллагаанд мөрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан билээ.

Ф.Кальер дипломат ажиллагааг *“Итгэл үнэмшил дээр тулгуурлан аливаа бодлогоо хэрэгжүүлвэл үр дүн ашигтайгаар гарах болно, итгэл бидэнд нээлттэй бодлогыг хэрэгжүүлэхэд тус болно, дипломатч хүн гэдэг нь үнэнч, шударга байх ёстой эс бөгөөс түүнд хэн ч итгэхгүй”* хэмээсний зэрэгцээ *“Дипломатч хүн оюун ухаанаа удирддаг, хичээнгүй, авьяастай хамгийн гол нь асар богино хугацаанд ашигтай шийдвэрийг гаргаж чаддаг, шийдвэр гаргахаасаа өмнө сайтар тунгаан боддог байх шаардлагатай”*<sup>22</sup> хэмээн тодорхойлж байв. Ф.Кальерийн энэ үзэл нь өнөөдрийг хүртэл үнэ цэнэтэй хэвээрээ байна.

Францад 17-18-р зуунд дипломат ажиллагааны үндсэн хэрэглүүр болох яриа хэлэлцээ хийх ур чадварын үндэс суурь тавигдсан ба Францын улс төр, цэрэг-эдийн засгийн хүчирхэгжилттэй холбоотойгоор Франц хэл нь тухайн үед улс төр-дипломатын үндсэн хэлд

тооцогдож байсан латин хэлийг шахаж олон улсын харилцааны үндсэн хэл болж чадсан байна.

Францын хувьсгалын үед дипломат албаны үйл ажиллагааг хянах тусгай байгууллагыг 1790 оны 7 сард байгуулсан бөгөөд тус байгууллагыг Маркиз Мирабо тэргүүлж байлаа. Улмаар элчин сайд хэмээх нэр томъёог хүчингүй болгосон ба гадаад улсад суух Францын төлөөлөгчдийг “Францын нунци” хэмээн нэрийддэг болжээ. Гадаад харилцааны төрийн байгууллагын оронд 2 улс төрийн хэлтэс мөн 6 газарзүйн хэлтсийг бий болгосон байна. Анхандаа Францын элчин сайдын яамдыг өндөр хэргэм зэрэгтэй санваартнууд тэргүүлдэг байсан бол аажимдаа энэ алба шашнаас ангид байх болжээ.

1797 онд буюу Францын хувьсгалын дараачаар Францад бий болсон Директорын Засгийн газрын гадаад хэргийн сайд болсон Шарль Морис де Талейран гадаад харилцааны бүхий л эрх мэдлийг өөртөө авсан ба үүнээс өмнө Францын гадаад бодлого, улс төрийн тогтолцоонд бий болоод байсан шийдвэр гаргалтын хямралыг зохицуулж чаджээ. Шарль Морис де Талейран хэмжээлшгүй эрхт хаант засаглалыг шинэчлэхэд чухал үүргийг гүйцэтгэсэн юм. Тэрээр маш олон төрлийн авьяастай байсан бөгөөд тэдгээр чадваруудаа ашиглан Франц болон Европын улс төрийн болон дипломат ажиллагааны онцлогийг 1789 оны Францын Хөрөнгөтний Хувьсгалаас 19-р зууны 30-аад оны

21 Попов.В.И. Современная дипломатия: теория и практика. Москва., 2000. стр. 14

22 François de Callières, The Practice of Diplomacy, translation of "De la manière de négocier avec les souverains," (London: Constable & Co, 1919) pp. 54-55



хагас хүртэл хадгалан авч үлдэж чадсан юм.

Тэрээр дипломат албыг шинэчлэх тухай, ямар зарчмыг баримталвал гадаад бодлого, дипломат ажиллагааны амжилтанд хүрэх талаар санал боловсруулан 1800 оны 1 сард “Шинэлчлэлийн тухай тогтоол”-ыг Засгийн Газраар батлуулсан байна.<sup>23</sup> Энэхүү шинэчлэлийн хүрээнд Шарль Морис де Талейран Францын дипломат албыг “төвийн” болон “хилийн чанадад дахь” хэмээх хоёр үндсэн хэсэгт хуваасан ба Гадаад Хэргийн Яаманд шинэ хэлтсүүдийг бий болгосон. Төвд ажиллах дипломатчид болон хилийн чанадад томилогдон ажиллах дипломатчдад ондоо шалгууруудыг тавих болсон бөгөөд хилийн чанадад томилогдон ажиллах дипломатуудад маш өндөр шалгуурыг тавих болсон байна.<sup>24</sup> Мөн тэрээр худалдааны харилцаа болон консулын албыг газар нутгийн хувьд Хойд болон Өмнөд гэсэн 2 хэсэгт хуваасан. Мөн түүнчлэн тэрээр дипломатчдын ахлах дараалал, зэрэг дэвийг анх бий болгож улмаар 1815 онд Венийн Их Хурлаас баталсан регламентаар хилийн чанадад суух дипломат төлөөлөгчдийн ахлах дарааллыг баталгаажуулж (*элчин сайд, элчин, хэргийг хамаарагч гэсэн 3 зэргийг бий болгосон*) чадсан юм.<sup>25</sup> Венийн Их Хурлаар хурлаар нийт Европын болон Францын асуудлыг хэлэлцсэн ба хуралд оролцсон их гүрнүүд өөрт

ашигтай газар нутгийн хувиарлалт хийхийг хичээн хоорондоо зөрчилдөж байв. Шарль Морис де Талейраны байгуулсан бас нэг гавъяа нь ялагдал хүлээгээд байсан Франц улсыг хүчирхэг хэвээр үлдээх зорилготой ирж улмаар санасандаа хүрч чадсан явдал юм. Энэ нь түүний дипломат арга ажиллагаа, яриа хэлэлцээ хийх ур чадвар ямар өндөр байсныг тод харуулсан үйл явдал болсон. Тус Их Хуралд оролцсон улсууд өөр хоорондоо тэгш эрхтэй байхыг зааж өгсөн бөгөөд хүчирхэг их гүрнүүд болох Орос, Их Британи, Прусс, Австри зэрэг улсууд Францын хүч чадавх, нөлөөний хүрээг хүлээн зөвшөөрсөн юм.

Францын хувьсгал болон Наполеоны эрин үе нь Францын улс төр, нийгмийн тогтолцоонд хэд хэдэн өөрчлөлтийг бий болгосон ба Венийн Их Хурлын дараачаар Францын хаан ширээнд суусан Бурбоны удмын хаад болох 18-р Людовик болон 10-р Карлын үед гадаад бодлого, дипломат ажиллагааны шийдвэр гаргалтад өмнөх үеэс онцын өөрчлөлт ороогүй билээ.<sup>26</sup> Энэ үед Францын голлох шийдвэрүүд зөвхөн Парист гарч байв. 1814 онд баталсан Үндсэн хуулийн дагуу хаан нь хуурай замын болон усан замын цэрэг армийг удирдахаас гадна дайн зарлах, энх тайван тогтоох, цэрэг стратеги, худалдааны гэрээ байгуулах, улс төрийн албан тушаалтныг томилох гэх мэт эрх мэдлээр хангагдаж байв.<sup>27</sup>

23 Yves Bruley. The Napoleonic diplomatic corps. Dans *Napoleonica*. La Revue 2009/1 (N° 4), pages 30 à 49

24 Мөн тэнд.

25 1818 оны Аахены протоколоор 4 зэргийг бий болгосон. Үүнд: Элчин сайд, элчин, төлөөний сайд, хэргийг хамаарагч. Төлөөний сайд нь дипломат практикт үлдэж чадаагүй.

26 Christophe Charle, *A Social History of France in the 19th Century* (1994) pp 7–27

27 The Charter of 1814, Form of the Government of the King: Article 14

Францын 2-р Бүгд Найрамдах Улсын үед (1848-1852) Гадаад Хэргийн Яамандаа зориулж шинэ барилга (1844-1853 онд баригдаж дууссан) барьж эхэлсэн бөгөөд тус барилга нь Кэ д'Орсэ гудманд эдүгээг хүртэл байрлаж байна. Францын түүхэнд хамгийн удаан хугацаанд оршин тогтносон Францын 3-р Бүгд Найрамдах улсын үед Францын гадаад бодлого, дипломат ажиллагаанд томоохон өөрчлөлт орсон байдаг. 1875 оны Үндсэн Хуулийн дагуу гадаад бодлогын шийдвэр гаргах эрх мэдэл Засгийн Газарт шилжсэн ба 7 жилийн хугацаатай томилогддог ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлаж өгсөн байна. 1648 оны Вестфалийн гэрээний дараачаас Европт тогтоод байсан “Консулын алба” болон “Дипломат алба”-ыг тусад нь авч үзэх хандлагыг 1880-аад оны үеэс Францчууд мөн анх өөрчилсөн билээ. Учир нь энэхүү хоёр алба нь адилхан төвийн болон хилийн чанад дахь нэгжүүдээс бүрддэг бөгөөд хэдийгээр консулын алба нь нэр хүнд, ахлах дараалал, эрх ямба дархан эрхийн хувьд дипломат албанаас ялгаатай ч харилцан бие биенээ нөхөн ажиллаж болох юм гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг.<sup>28</sup>

XIX-XX зууны зааг дээр олон авъяаслаг дипломатчид Францын Дипломатын Академиас төрөн гарсны дотор ах дүү Поль болон Жюль Камбон, Баррер, Жюссеран нар багтаж байлаа. Тэд Францын гадаад бодлогод хүчтэй нөлөөг үзүүлж чадсан юм. Тэдний боловсруулсан үзэл баримтлал

Францад төдийгүй хилийн чанадад ч мөн адил нөлөө ихтэй байсан юм. Жюль Камбон өөрийн дипломатын туршлага дээрээ тулгуурлан бичсэн “Дипломатч” хэмээх бүтээл нь түүнд асар их алдар нэрийг авчирсан. Түүнийхээр *“Дипломатч гэдэг нь оюун ухааны хувьд биеэ даасан, ухаалаг байхаас гадна аливаа асуудалд дүн шинжилгээ хийх, оновчтой дүгнэлт гаргах чадвартай байх шаардлагатай”* хэмээн тодорхойлжээ. Энэ үеийн Францын дипломатчдын дотор олон нэрт зохиолчид байсан. *“Иймдээ ч Францын дипломатын баримт бичгүүд уран яруу, хэллэг сайн, нарийн няхуур боловсрогдсон байдаг бөгөөд утга агуулгаараа ялгарч байдаг. Ялангуяа тэд өөрсдийн нэр хаягаар ирсэн утга найруулга сайтай захидал бичгийг ихэд үнэлдэг байсан ажээ”*<sup>29</sup> хэмээн Оросын нэрт дипломатч В.И.Попов өөрийн бүтээлдээ дурьдсан байдаг.

Дэлхийн II дайны дараачаар Франц улс нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүнээр сонгогдож улмаар ЗХУ, АНУ, Их Британи, БНХАУ-тай адил эрх эдлэх болжээ. Шарль Де Голль 1958 онд засгийн эрхэнд дахин гарснаар Францын 5-р Бүгд Найрамдах улсыг байгуулсан юм. Энэ үед Францын дипломат албаны бүтэц зохион байгуулалт, гадаад бодлогын бодлого боловсруулалт болон хэрэгжилтэд бодитой өөрчлөлтүүд гарч эхэлсэн хэдий ч өнгөрсөн үед тогтсон Францын дипломатын дэг сургуулийн хэв маягт онцын өөрчлөлтүүд ороогүй байна.

28 <https://www.britannica.com/topic/foreign-service>

29 В.И.Попов. Орчин үеийн дипломат ажиллагаа: Онол, практикийн асуудал. “Ган Принт”, УБ., 2007. 212 дахь тал

## Дүгнэлт

Ийнхүү 15-р зууны үеэс үндэс сууриа тавин хөгжиж эхэлсэн Францын дипломат ажиллагаа, дипломат алба нь 19-р зууны эхэн үе гэхэд өнөөгийн хэлбэр, хэв маягаа олсон төдийгүй Европын улсууд төдийгүй дэлхийн бусад улсын дипломат ажиллагаанд хүчтэй нөлөө үзүүлсэн байна. Дипломатын түүх судлаачид орчин үеийн дипломат ажиллагааны дэг сургуулийн үндсийг Дорнын зарим улс болон Итали, Англи, Францыг тавьсан хэмээн үздэг. Гэхдээ Францын дипломат ажиллагаа бусдыг бодвол илүү нарийн өвөрмөц онцлогтой гэдэг дээр олон арван судлаачид санал нэгддэг. Хэдийгээр Италийн хот улсууд болон Англитай харьцуулбал хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газраа хожуу байгуулж эхэлсэн ч өмнөх хоёр улсаа бодвол Франц нь дипломат ажиллагааг агуулгын хувьд болон дипломат албыг бүтэц зохион

байгуулалтын хувьд төгөлдөржүүлэх, шинэчлэх тал дээр ихээхэн амжилт олсон төдийгүй орчин цагийн дипломат ажиллагаа, дипломат албаны үндсэн ойлголт, нэр томъёо, бүтэц зохион байгуулалтын үндэс суурийг тавьж өгчээ.

Дээрх бүгдээс эцэслэн дүгнэхэд Францын дипломат ажиллагаа, дипломатын дэг сургууль нь орчин цагийн дэлхийн дипломат ажиллагаанд асар их нөлөө үзүүлсэн бөгөөд дипломат ба консулын эрх зүй, дипломат ажиллагааны хэв маяг, дипломат ажиллагаан дахь шударга байдал, дипломат албаны бүтэц зохион байгуулалт, дипломатын нэр томъёо, дипломатын хэл ба баримт бичиг боловсруулалт, дипломатчдыг бэлтгэх тогтолцоо болон дипломатчдад тавигдах шалгуурыг бий болгосон голлох улс нь Франц гэдэг нь батлагдаж байна.

## Ашигласан материал

### Ном, эрдэм шинжилгээний өгүүлэл:

#### *Монгол хэл дээр:*

1. Баасанхүү. Г, Оюунсүрэн. Д, Баттогтох. Ж, Энхцэцэг. С, Оюунсүрэн. С, Баясгалан. С. Олон улсын харилцааны үндэс ба даяаршил. МУИС Пресс Хэвлэлийн Газар. УБ., 2016.
2. Попов. В.И. Орчин үеийн дипломат ажиллагаа: Онол, практикийн асуудал. “Ган Принт”, УБ., 2007.

#### *Гадаад хэл дээр:*

1. Зонова. Т.В. Дипломатия Иностранных Государств. Москва., 2004.
2. Никольсон. Г. Дипломатическое искусство. М., 1962.
3. Петров. В.П., Владимаров. Ю.В. Кэ д’Орсэ. Москва., 1966.
3. Попов. В.И. Современная дипломатия: теория и практика. Москва., 2000.
4. Amalia D. Kessler. A “Question of Name”: Merchant-Court Jurisdiction and the Origins of the Noblesse
5. Christophe Charle, A Social History of France in the 19th Century, 1994.
6. François de Callières. The Art of Diplomacy. University Press of America, 1994.
7. Wael Jabbar Jouda, Anass Hamza Mahdib. “The Role of Louis XI in France’s Foreign Policy (1461-1483)”
8. Zagorin, Perez. Rebels and Rulers, 1500–1660. Volume II: Provincial rebellion: Revolutionary civil wars, 1560–1660. Cambridge: Cambridge University Press. 1992.
9. Yves Bruley. The Napoleonic diplomatic corps. Dans Napoleonica. La Revue 2009/1
10. Kayte Rath, French diplomatic service is the world’s best, UK says, BBC News, 8 November 2012
11. International Journal of Innovation, Creativity and Change. Volume 12, Issue 12, 2020.
12. Commerçante. <https://stacks.stanford.edu/file/druid:jb240xh0328/kessler.pdf>
13. The Charter of 1814, Form of the Government of the King: Article 14

**Цахим эх сурвалж:**

1. <https://www.britannica.com/topic/foreign-service>
2. [https://www.ijicc.net/images/vol12/iss12/121218\\_Joud\\_2020\\_E\\_R.pdf](https://www.ijicc.net/images/vol12/iss12/121218_Joud_2020_E_R.pdf)
3. <https://www.diplomatie.gouv.fr/ru/o-ministerstve/istoriya-ministerstva-i-ego-znakovyh-zdanij/article/decouvrir-l-histoire-et-les-lieux-emblematiques-du-ministere>

## **French influence on modern diplomacy**

***Myagmardorj Purevdorj***

*Senior Lecturer, Ph.D.*

*Department of International relations and Social studies*

*University of the Humanities, Ulaanbaatar, Mongolia*

*myagmardorj@humanities.mn*

***Abstract:*** *Undoubtedly, France is a country that has been shaping the school of diplomacy, institutional structure, terminology and diplomatic ranks in modern diplomacy. Diplomacy and the diplomatic service in France have an immense historical tradition, alongside it, having a large impact on development in diplomacy, not only in European states but also, throughout the world. Since the establishment of the diplomatic service, French governments prioritized their diplomatic service, strived to improve, develop it further; in addition, they extensively trained their diplomats, continuing to enhance their competencies According to theories, concepts and records of diplomacy researchers and historians, France established the foundation of modern diplomacy, its tactics and implementation; furthermore French language replaced Latin in the field of international relations, making French the main language of diplomacy from the 18th century to the present day.*

*In this article author aims to review the contribution of the French diplomatic school to modern diplomacy and its historical impact.*

***Keywords:*** *Modern diplomacy, diplomatic service, French diplomacy.*

*The day of submission:* 2020.10.29

*Completion of review:* 2020.11.5

*Final decision for acceptance:* 2020.11.6